

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1071

танай _____ -ны № _____ -т

Г Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох “Эх орончдын нэгдсэн нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аudit MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

Дүгнэлт

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохор “Эх орончдын нэгдсэн нам”-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Эх орончдын нэгдсэн нам”-ын мөрийн хөтөлбөр /...../ 16, хуудас-ийг хавсаргав

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan_Bichig\20240420 GNAG-3.Docx

0001030679

Эх орончдын нэгдсэн намын НАМ

2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн

хурлаар батлав.

УЗН01734 8489108

- Монгол Улсад ардчилсан ёс гажуудан, дүр эсгэсэн ардчилал тогтох,
- Монгол Улсад шударга ёс адлагдан, авлига, ашиг сонирхол цэцэглэж,
- Монгол Улсад эрх чөлөө завхран, дур зорго эзэрхэж,
- Монгол Улсад тэгш байдал алдагдан, нийгмийн ялгаа чинээндээ тулж,
- Монгол Улсад үндэсний эв нэгдэл хэврэгшин, оюун санааны задрал нүүрлэж,

-Монгол Улсад хууль дээдлэхийг умартан, хүний засаглалд урваж буй нь эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх Үндсэн хуулийн зорилгыг бүдэгрүүлж, улсын хөгжил, хойчийн ирээдүй, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг хөсөрдүүлж байх тул гагцүү Монгол Улсын ашиг сонирхол, Монголын ард түмний үнэт зүйл, эрхэм зорилгыг нандигнан хамгаалж, сахин биелүүлэх нэг санаа, нэгдмэл үйлсэд нэгдсэн Эх орончид БИД:

Монгол Улс, Монгол төр, Монголын ард түмний оршин тогтонох, мандан бадрахын язгуур үндэс, дээд эрэмбэ бол улс үндэсний ашиг сонирхол байх бөгөөд төр, нийгэм, хамтлаг, хувийн эрх ашиг, сонирхол энэхүү бодлогод захирагдмал байхыг тухаглан “Эв нэг эх орон-Зөв хүн эх оронч” уриатай мөрийн хөтөлбөрөө өргөн дэвшүүлж байна.

ЭХ ОРОНЧДЫН НЭГДСЭН НАМЫН

2024 оны УИХ-ын №00000000
2024 оны УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр

Зорилт 1. ТӨРИЙН ХҮРЭЭНИЙ БОДЛОГО:

Төрд тогтсон намын дэглэм, мафижсан бүлэглэл, төрлийн алба, бохир хууль, хяналтын тогтолцоог халж, мэдлэгт суурилсан хүчтэй төр, бодлого төлөвлөгөөт зөв засаглалыг тогтоож, ард түмнийхээ төрдөө итгэх итгэлийг бид эргүүлэн авчирна.

Шинэ Үндсэн хууль

- 1.1 Шинэ Үндсэн хуулийн төслийг санаачилж, хоёр шатлалтай парламент бүхий тогтолцоог дэмжих бодлого баримтлана.
- 1.2 Шинэ Үндсэн хуулийн төслийг санаачилж, Ерөнхий сайдас бусад Засгийн газрын танхимын гишүүд парламентын гишүүн бус, мэргэжлийн байх бодлого дэвшүүлнэ.



00000001

- 1.3** Шинэ Үндсэн хуулийн төслийг санаачилж, УИХ-ын гишүүний халдашгүй байдлыг цуцалж, сонгогчид нь эргүүлэн татдаг тогтолцоог бий болгох бодлого баримтлана.
- 1.4** Ард түмний бүрэн эрх, нийтийн эрх, эрх чөлөөг Үндсэн хуулиар баталгаажуулна.
- 1.5** Газар нутаг, байгалийн баялаг ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх онцгой өмч гэж үзэж, хяналт бүртгэл, өмчлөх, эзэмших, ашиглах эрх, хариуцлагын тогтолцоог үндэсний ашиг сонирхолд нийцүүлэн хуульчлан шинэчлэнэ.
- 1.6** Шинэ Үндсэн хуулийн төслийг санаачилж, Үндсэн хуулийн цэцийн статусыг өөрчлөх, чиг үүргийг өргөжүүлэх, цэцийн гишүүний шалгуурыг сайжруулах бодлогын санал дэвшүүлнэ.
- 1.7** Шинэ Үндсэн хуулийн төслийг санаачилж, Прокурорын байгууллагын хяналтын эрх мэдлийг өргөжүүлж, хэрэг мөрдөн шалгах эрх олгохыг дэмжинэ.
- 1.8** Үндсэн хуулийн байгууллага болох Үндэсний аудитын газрын эрх хэмжээ, хариуцлагыг нэмэгдүүлэх, бодлогоор зөрчилийн хэрэг нээх, бүртгэх эрхийг хуулиар олгохыг дэмжинэ.
- 1.9** Инфляци, мөнгөний ханшны уналттай уялдуулан цалин, тэтгэвэр, тэтгэмжийг заавал индексжүүлэхээр хуульчилж, төрийн нийгмийн хариуцлагыг өндөржүүлнэ.

Хүчтэй төр, зөв засаг

1.13 Төрийн захиргааны, тусгай, үйлчилгээний албан хаагчдын намын гишүүнчлэл, дэмжигч статусыг хориглож, төрийн албыг улстөрийн хараат байдлаас бүрэн чөлөөлнө.

1.14 Хатуу гишүүнчлэлээр барьцаалах, сум, орон нутагт салбартай байх, хандив, тусламж авах, үл хөдлөх хөрөнгө эзэмших, төрийн албаны үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр хутгалдахыг намуудад хатуу хориглож, мэргэшсэн улстөрчдийн хязгаарлагдмал гишүүнчлэлтэй, дэмжигчдийн статустай, сонгуульд авсан суудлын тоогоор төсвөөс санхүүждэг, байрны хангамж эдэлдэг, улс орны хөгжлийн бодлого боловсруулж улс төрийн сангаас санхүүжүүлдэг институц байхаар хуульчилж, намуудыг татан буулгаж дахин бүртгэл явуулна.

- 1.15** Төрийн жинхэнэ албыг улстөржүүлж, нөлөөллөө аливаа хэлбэрээр тогтоосон намыг татан буулгана.
- 1.16** Нутгийн өөрөө удирдах ёсыг иргэдийн мэдэлд бүрэн шилжүүлж, бүх шатны Иргэдийн хурлын сонгуулийг намаас ангид явуулах эрх зүйн орчныг үе шаттайгаар бүрдүүлнэ.
- 1.17** УИХ-д суудалтай эрх баригч намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн биелэлтэд ээлжит сонгууль зарлахаас барын өмнө Үндэсний аудитын газраар аудит хийлгэж, сонгогчдод мэдээлнэ.



00000002

- 1.18 Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Үндсэн хуулийн цэц, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний аудитын газар, Үндэсний бүртгэл, статистикийн газар, Авиалгатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Үндэсний олон нийтийн радио, телевизийн дарга нар, Монголбанкны Ерөнхийлөгч, Улсын Ерөнхий прокурорыг улстөрийн намын гишүүн, улстөрч томилохыг хориглож, мэргэжлийн холбоо, олон нийтийн байгууллага, иргэдээс нэр дэвшүүлж, парламент батламжлахаар хуульчилна.
- 1.19 Сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан бодлого, зорилтуудыг биелүүлэхийн тулд Засгийн газрын бүтцийг хуулиар тогтооно.
- 1.20 Засгийн газрын тохируулагч агентлаг Үнэ, стандартын хороог байгуулж, хэрэглээний үнийн зах зээлийн судалгаа, жишиг үнийг нэгдмэл байдлаар гаргаснаар үнийн монополи, тендер, худалдан авалтын луйврыг арилгаж, гааль, татварын ажлыг хөнгөвчилийн.
- 1.21 Төрийн улс төрийн албан хаагч, төрийн захиргааны албан хаагч, төрийн тусгай албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагчийн эрх зүйн байдлын тухай багц хуулийг батлан гаргаж тухайн төрийн алба бүрийн шалгуур үзүүлэлт, стандарт, эдлэх эрх, үүрэг, хариуцлага, хангамж, карьерийн зарчмыг тодорхой тусган хэрэгжүүлэх бөгөөд хуулийн дагуу дахин аттестатчлал явуулна.
- 1.22 Төрийн албаны зөвлөлийн статусыг хараат бус, олон нийтийн байхаар өөрчилж, зөвлөлийн бүрэлдэхүүнд төрд татвар төлдөг, төрөөр үйлчлүүлдэг байгууллага, иргэний нийгэм, иргэдийн төлөөллийг тэнцвэртэй, өргөн хүрээтэй оролцуулж, нийгэм, олон нийтийн хяналтын механизмыг төлөвшүүлнэ.
- 1.23 Засгийн газрын дэргэд Хүний нөөцийн тусгай хороог байгуулж, шилдэг мэргэшсэн боловсон хүчнийг төрд ажиллуулах, чадамж, бүтээлд сууриссан хүний нөөцийн сан бий болгоно.
- 1.24 Үндэсний аюулгүй байдал, хууль, хяналт, батлан хамгаалах салбар болон гадаад бодлого, стратегийн ач холбогдолтой ашигт малтмал, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх байгууллагуудын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтныг томилохдоо уг хүний нөөцийн санд бүртгэлтэй, мэргэшсэн боловсон хүчинээс зөвхөн сонгоно.
- 1.25 Төрийн албаны шалгалтыг боловсронгуй болгож, олон улсын жишигийн дагуу нийтлэг ерөнхий шалгалтаас гадна тухайн салбарын онцлогтой мэргэжлийн шалгалт авдаг болгоно.
- 1.26 Төрийн албанд гаднаас ажил үүрэг гэрээгээр гүйцэтгэх боломжийг нээж, үргүй зардал, орон тоог хэмнэх, төрийн албаны зарим салбарт ажлын цагийн уян хатан систем (Flextime system) нэвтрүүлнэ.

00000073

- 1.27 Төрийн албандаа ажиллагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Төрийн албан хаагчдын холбоог шинээр байгуулна.
- 1.28 Сонгуулийн хуулинд төр ба ард түмний хооронд гэрээ байгуулах заалтыг нэмж оруулах замаар ард түмний хяналтыг тогтоож, хариуцлагатай улс төрийг бий болгоно.
- 1.29 Парламент бүрэн эрхийн хугацааны эхний хагаст Сонгуулийн хуулийг өөрчилж болох бөгөөд үүнийг үндэсний зөвшилцөлгүйгээр хийхийг хориглоно.
- 1.30 Оффшор банкинд данс, хадгаламжтай этгээдийг бүх шатны сонгуульд нэр дэвшиүүлэх, төрийн албандаа томилон ажлуулахаас татгалзана.
- 1.31 Парламентад суудалтай болон суудалгүй намуудын Улстөрийн байнгын зөвлөлийг парламентийн дэргэд байгуулна.
- 1.32 Төрөөс улстөр-бизнесийн олигархи бүлэглэлийг зайлцуулж, өөрсдөөр нь хүлээн зөвшөөрүүлж, ард түмнээс завшсан хөрөнгөө ядуурлыг бууруулах үйлсэд зориулахыг шаардана.
- 1.33 Цэрэг, цагдаа, тагнуулыг улс төрөөс хараат бус байлгаж, ард түмний эсрэг ашиглахыг хориглоно.
- 1.34 Гадны шашны гаж нөлөө, соёлын түрэмгийлээс үндэсний оюун санаа, үнэт зүйлс, соёлыг хамгаалах бодлого явуулна.
- 1.35 Үндэсний зан заншил, соёл, урлагадар дамжуулан үндэсний бахархлыг төлөвшүүлнэ.
- 1.36 Хэвлэл, мэдээллийн хэрэгслийг улс төр, эдийн засгийн бүлэглэлийн нөлөөнөөс ангижруулж, олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлнэ.
- 1.37 Шинжлэх ухааны салбарыг улстөрөөс хараат бус байх тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.38 Үзэл бодлоор ялгаварлах, хавчин гадуурхах, мөрдөн мөшгих аливаа илрэлтэй хатуу тэмцэнэ.

Уул уурхай

- 1.39 Ашигт малтмалын төрөл, ордын нөөцийг харгалзахгүйгээр байгалийн баялаг улсын өмч гэж үзэж, ард түмэн бүрэн хянах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 1.40 Монголын уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэлгээг сайжруулахад онцгой анхаарч, үнийн нэгдсэн бодлого зохицуулалт хийнэ.
- 1.41 Монгол Улсын Засгийн газарт мэдэгдэлгүйгээр олон улсын гадаад зах зээлд монголын баялгийг барьцаалан хөрөнгө босгох, зөвшөөрөлгүйгээр эрх шилжүүлэх, худалдахыг хориглоно.

00000074

- 1.42 Үндэсний эрх ашигт харшилсан олон улсын гэрээ, хэлцлүүдийг дахин хянаж, хамтрагч этгээдтэй хэлэлцэн, засч запруулах, сайжруулах арга хэмжээ авна.
- 1.43 Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг шинэчлэн сайжруулах гарцыг олж, үндэсний эрх ашигийг хохирохгүйгээр шийдвэрлэнэ.
- 1.44 Оюутолгой болон гадаад, дотоодын аж ахуйн нэгжүүдийн экспортын орлогыг зөвхөн Монголын банкаар заавал дамжуулах үүргийг хуульчилна.
- 1.45 Таван толгойн ордыг ард түмний мэдэлд 100 хувь үлдээж, төслийн хэрэгжүүлэх эрхийг үндэсний хөрөнгө оруулагчдад олгох бодлогыг туштай дэмжинэ.
- 1.46 Улсын төсвийн хөрөнгөөр эрэл хайгуул хийсэн болон стратегийн орд газруудын хууль бусаар олгогдсон лицензийг цуцалж, буруутай этгээдүүдэд хариуцлага тооцуулна.
- 1.47 Нөөц нь тогтоогдсон ордуудыг дахин нягталж, стратегийн ордод хамруулах эсэхийг шийдвэрлэнэ.
- 1.48 Дархан цаазт газар, төрийн тусгай хамгаалалттай газар, хилийн бүс, төв суурин газар хамруулан олгосон лицензийг цуцалж, малчдын хаваржаа, өвөлжөө, булаг шандны эх, оршуулалтын газрыг тусгай зөвшөөрлөөс хэсэгчлэн чөлөөлүүлнэ.
- 1.49 Байгалийн баялгийг өвөг дээдсийн буян, өнөө бидний хишиг, үр хойчийн өмч хэмээн үзэж, улсын төсвөөс ангид, хараат бус Үндэсний баялгийн сан байгуулж, ашигт малтмалын нөөц ашигласны татвар, хураамжийн орлогын 50 хувиас доошгүйг тогтолцоулж, төвлөрүүлэн ирээдүйд хадгална.
- 1.50 Ашигт малтмал олборлогч 303030 бүх аж ахуйн нэгж өмчийн хэлбэр харгалзахгүйгээр жил бүр Үндэсний нөөцийн санд уул уурхайн бүтээгдэхүүн борлуулсан ашгийн 10 хувийг төвлөрүүлэхээр хуульчилна.

Үйлдвэржүүлэлт

- 1.51 Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх төрийн бодлогын хэмжээнд тавьж, эрчимжүүлж, өндөр технологи нэвтрүүлсэн боловсруулах үйлдвэр, экспортод чиглэсэн экологийн цэвэр хүнсний үйлдвэрлэл болгон хөгжүүлж, малчин өрхийн болон жижиг дунд үйлдвэрийн хөнгөлттэй зээл, санхүүгийн арга хэрэгсэл, урамшуулал, хаягласан төсөл, хөтөлбөрөөр туштай дэмжинэ.
- 1.52 Үр тариа, хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, экспортод чиглэсэн органик бүтээгдхүүний үйлдвэрлэлийг төрөөс дэмжинэ.
- 1.53 Экспортын чиг баримжаатай эрчим хүч, дулаан, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрийг хувийн хөрөнгө оруулалтаар байгуулахыг дэмжинэ.



00000005

- 1.54 Үндэсний үйлдвэрүүдийг сэргээх, хөгжүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, уул уурхайн түүхий эдэд түшиглэсэн хүнд үйлдвэрийг бодлогоор дэмжин хөгжүүлнэ.
- 1.55 Газрын тос, кокс боловсруулах үйлдвэрүүдийг үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалтаар байгуулж, түүнийг түшиглэн нефть, кокс химийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 1.56 Зэс, төмөр, бусад металлын хүдэр боловсруулах үйлдвэрийг хувийн хэвшилийн хөрөнгөөр байгуулахыг татвар, зээлийн бодлогоор дэмжиж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилтыг хэрэгжүүлнэ.
- 1.57 Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнесийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар бүртгэл, тусгай зөвшөөрлийг хялбарчилж, татвар, зээлийн бодлого, санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан таатай орчин бүрдүүлнэ.

Хотжилт

- 1.58 Нийслэл Улаанбаатар хотын төлөвлөлтийг шинэчилж, эрх зүйн таатай нөхцөлтэй дагуул хотуудаар тэлэх бодлого баримтлана.
- 1.59 Улаанбаатар, Даархан, Эрдэнэтээс гадна баруун бүсэд Хархорин, Ховд, зүүн бүсэд Өндөрхаан, говийн бүсэд Ханбогд гэсэн бүсийн статустай хотуудыг байгуулж, хөнгөн, хүнд үйлдвэр, шинжлэх ухаан-үйлдвэр-технологийн парк, их дээд сургууль, мэргэжлийн сургууль, аялал жуулчлалыг бүсийн онцлогтой хөгжүүлнэ. ATA9693_9006109
- 1.60 Хүн амын тоо, эдийн засгийн чадавхи, дэд бүтцийн хөгжил, газар зүйн байршил, үндэсний аюулгүй байдалд үзүүлэх нөлөө зэрэг хүчин зүйлийг харгалzan засаг захиргааны нэгжийн өөрчлөлт шинэчлэлийг эхлүүлж, бус, аймгийн төвүүдийг орон нутгийн статустай хотын бодлогоор хөгжүүлнэ.
- 1.61 Аялал жуулчлалын үндэсний хөгжлийн хөтөлбөр, үндэсний сүлжээ байгуулж, аялал жуулчлалын тусгай бус, цогцолбор газруудыг хөгжүүлнэ.
- Дэд бүтэц**
- 1.62 Хэвтээ тэнхлэгийн төмөр замыг барьж эхлэх бодлогыг гаргана.
- 1.63 Улаанбаатар хотыг тойруулан 2 урсгалтай төмөр зам барих төслийг эхлүүлнэ.
- 1.64 Улаанбаатар хотын авто замыг бүрэн шинэчилж, замын ачааллыг бууруулахад чиглэсэн давхар зам, гүүр, гүүрэн гарц барих төслүүдийг концессоор шийдвэрлэхийг дэмжинэ.
- 1.65 Нийслэл, бус, аймаг, сумын гэр хорооллын дэд бүтцийн хөгжлийг дэмжих хуулийн төсөл санаачилж, суурин газрын гэр хорооллын бие даасан эко дэд бүтцийг хөгжүүлэхэд гадаад, дотоодын санхүүгийн эх үүсвэрээс дэмжлэг үзүүлэх журам мөрдүүлнэ.

00000006

1.66 Хот, суурин газрын нийтийн тээврийн асуудлыг хувийн хэвшлийн болон гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар бүрэн шийдвэрлэнэ.

Зорилт2. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНИЙ БОДЛОГО

Төсвийн алдагдал, хяналт, тооцоогүй гадаад, дотоод өр, өрийн сүлжээ, инфляцийн дарамт, дефляцийн аюул, төгрөгийн ханшны уналт, гадаад валютын ноёрхол, банкны зээлийн хүүгийн өсөлт, далд авилгалыг таслан зогсоож, үндэсний эдийн засгаа сэргээн бэхжүүлнэ.

Эдийн засаг

2.1 “Эдийн засаг, стратегийн ач холбогдолтой салбаруудад төрийн хяналт тогтоох тухай хууль” санаачлан батлуулж, өмнө хувьчлагдсан стратегийн ач холбогдолтой обьектуудад төрийн хяналтыг тогтоож, үр ашгийг дээшлүүлнэ.

2.2 Архи, согтууруулах ундааны үйлдвэрлэлд төрийн монополь тогтооно.

2.3 Монгол Улсын үндэсний нийт баялгийг үнэлж, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцлийг бүрдүүлнэ.

2.4 Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчилж, хөрөнгө оруулалтын төрөл, хэлбэр, онцлог, хэмжээ, эдийн засгийн үр өгөөж, ашгийн урсгал, байршил, дахин хөрөнгө оруулалт, түүний өсөлт 96 зэргийг 9023030583 харгалзан аливаа хөнгөлөлт, чөлөөлөлтэд хамруулдаг болно.

2.5 Үндэсний хөрөнгө оруулагчид тэргүүн ээлжинд дэмжих, илүү таатай нөхцөл олгох бодлого явуулж, тэднийг аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

2.6 Үнэт цаасны зах зээлийн хөгжлийг гүнзгийрүүлж, Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг дэлхийн жишигт хүргэж, иргэд сонирхсон хувьцаагаа чөлөөтэй арилжих, эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.

2.7 Ипотекийн зээлийн боломжийг өргөжүүлж, хүүг бууруулж, бага орлоготой иргэд, малчид, гадаадад ажилладаг иргэд, залуу гэр бүл хамрагдах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.8 Хөрөнгө оруулалтыг татах, менежментийг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийг хувьчлахыг дэмжинэ.

2.9 Импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлж, ижил төстэй барааны экспортыг татвараар хязгаарлана.

00000007

2.10 Экспортыг дэмжиж, монгол бүтээгдэхүүн гадаадын зах зээлд нэвтрэх таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогыг идэвхжүүлж, эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлнэ.

2.11 Хоёр хөрштэй эдийн засгийн коридор байгуулах, тарифын хөнгөлөлт эдлэх, гуравдагч орнуудын зах зээлд харилцан татваргүй бараа нийлүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

2.12 Монгол Улсын стратегийн бараа бүтээгдэхүүний импортын үндсэн чиглэлийг шинэчилж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний татварыг ялгавартай тогтоож, “Өдөр тутмын худалдан авалтын тухай хууль” санаачлан хэрэгжүүлнэ.

2.13 Иргэдийн ахуй амьдралд зохицсон уян хатан санхүүгийн бичил үйлчилгээг нэвтрүүлж, ажилтай, орлоготой иргэдээ бодлогоор дэмжиж, хүчирхэг дундаж давхаргыг бий болгохыг зорино.

2.14 Тогтвортой хөдөлмөр эрхлэлт, өрхийн бизнесийн санааг хөхиулэн дэмжих, тэтгэх зорилгоор Тусгай сан бий болгоно.

2.15 “Монгол иргэдийн амьжиргааны орчин нөхцлийг хамгаалах тухай хууль” боловсруулж батлуулна.

2.16 Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүн хэрэглэгчдийг татварын бодлогоор дамжуулан урамшуулах хууль санаачилна.

2.17 Стратегийн ач холбогдол багатай төрийн өмчийг ажилтнуудын эрх ашгийг хохирохгүйгээр хувьчлах бодлого барьж, үр ашгийг нь дээшлүүлнэ.

2.18 “Ард түмний IPO” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, эхний ээлжинд зөвхөн Монгол Улсын иргэдэд Тавантолгойн ордын 30 хувийг Монголын хөрөнгийн биржээр хаалттай арилжаалж, хөрөнгийг босгоно.

2.19 Сумын эмч, Сумын багш, Хөдөөгийн залуу гэр бүл, Хөдөөгийн фермер зэрэг зорилтот хөтөлбөрүүд хэрэгжүүлж, орон сууцны ипотек, бичил үйлдвэрийн франчайзинг, техник тоног төхөөрөмжийн лизингээр дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

2.20 Малчдын өвөлжөөнд өвлүйн тохилог сууц барих хөдөлгөөн өрнүүлж, арилжааны банкны болон орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамруулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Мөнгө санхүү

2.21 Улсын төсвийн алдагдлыг 3 жилийн хугацаанд үе шаттайгаар бүрэн зогсоож, цаашид алдагдалтай төсөв батлахыг хориглоно.

00000078

- 2.22 Үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг санаатайгаар унагааж, санхүүгийн хямрал зохиомлоор үүсгэсэн бол үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт тооцож, хуулийн дээд хариуцлага ногдуулна.
- 2.23 Монголбанкны тогтолцоог Үндсэн хуулинд захируулан өөрчилж, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглоно.
- 2.24 Төлөх боломжгүй, өндөр хүүтэй мөнгө хүүлэх Монголбанкны бодлого, арилжааны банкны тогтолцоог засна.
- 2.25 Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэд хараат бус Мөнгөний бодлогын хяналтын тусгай хороог байгуулж, мөнгөний бодлогын хэрэгжилт, мөнгөний нийлүүлэлт, бодлогын хүүгийн түвшин, своп хэлэлцээр, өрийн үзүүлэлт, зээлийн нөхцөлд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлнэ.
- 2.26 Төгрөгийн ханшны огцом уналтаас урьдчилан сэргийлэх, эрсдлээс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг хамгаалах, хохирлыг хөнгөвчлөх хууль эрх зүй, даатгалын тогтолцоог бүрдүүлнэ.
- 2.27 Монгол Улсад зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр төлбөр, гүйлгээ гүйцэтгэж, зээл олгох бөгөөд гадаад валютын зээлийг үүрэг үүсэх үеийн ханшаар тооцох тухай Иргэний хуулийн 218.1 заалтыг заавал мөрдүүлэхийн төлөө тэмцэнэ.
- 2.28 Арилжааны банкууд дахь долларын зээлүүдийг зээлдэгчид болон банкинд алдагдалгүйгээр хуульд заасан ханшаар төгрөгийн зээл болгон шилжүүлнэ.
- 2.29 Төгрөгийн зээлийг валютын зээлд хувиргахыг хориглож, журмыг зөрчсөн банкыг зээлийн дүнгээр торгох, эрхийг хураах хүртэл арга хэмжээ авна.
- 2.30 Арилжааны банкны мөнгө хүүлэх хэд ашгийн төлөө үйл ажиллагааг таслан зогсоож, санхүүгийн үйлчилгээний байгууллагын шинж чанарыг түлхүү төлөвшүүлнэ.
- 2.31 Өрийн менежментийг боловсронгуй болгож, өрийн тооцооллыг олон улсын стандартад нийцүүлж, Засгийн газрын өрийг давхар өрийн зээлээр төлөхийг хориглоно.
- 2.32 Монголбанкнаас Засгийн газрын өрийг санхүүжүүлэх, мөнгө хэвлэж төсвийн алдагдал нөхөхийг хатуу хориглоно.
- 2.33 Засгийн газар Монголбанкны валютын нөөцөөс давсан өргүй байх зарчмыг тогтооно.
- 2.34 Эдийн засгийн хямрал, төсвийн алдагдалтай үед бүтээн байгуулалтын зээл авахыг хориглож, төсвийн орлогыг иргэддээ өндөр торгууль шийтгэл ногдуулах аргаар нөхдөг ёс суртахуунгүй бодлогыг хална.
- 2.35 Засгийн газрын өрийн бичгийн нийлүүлэлт, хүүгийн түвшинд тавих хөндлөнгийн хяналтыг сайжруулж, дээд хязгаар тогтооно.
- 2.36 Орлого, ашгаас нь үл хамаарсан татварын бодлого, тогтолцоог засч залруулна.

ОПОППОПП

- 2.37 Эдийн засгийн хямралын үед зээлийн дарамт, ханшийн уналтад өртсөн жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд тодорхой хугацаагаар татвар, даатгалын шимтгэлийн "амралт" олгох хууль санаачилна.
- 2.38 УИХ-аас татварын хөнгөлөлтийн тухай хууль, Засгийн газраас татварын өршөөлийн хууль санаачлахыг хориглоно.
- 2.39 Төгрөгийн худалдан авах, хөрвөх чадварыг дээшлүүлэх, ханшийг чангaruулах хатуу бодлого барина.
- 2.40 Инфляцийн өсөлттэй уялдуулан цалин, тэтгэвэр, тэтгэмжийг тогтмол индексжүүлнэ.
- 2.41 Төрийн нэрээр авах гадаадын улс, олон улсын байгууллагын төслийн зээлийг түүний нөхцөл, үр өгөөжийг харгалзан шийдвэрлэх зарчимд шилжиж, бага хүйтэй, удаан хугацаатай, аливаа нөхцөл болзолгүй, зайлшгүй хэрэгцээт арилжааны зээлийг авахыг дэмжинэ.
- 2.42 Засгийн газрын тусгай сангруудын менежментийг төсөвт байгууллагаас тусгаарлаж, бие даалгах чиглэл барина.
- 2.43 Татвар төлөгчдийн мөнгийг үргүй зарцуулах, шамшигдуулахын эсрэг тэмцэж, ялын бодлогыг чангaruулна.

Зорилт3. НИЙГМИЙН ХАМГААЛЫН ХҮРЭЭНИЙ БОДЛОГО:

Боловсрол, эрүүл мэндийн чанартай, халамжийн оновчтой, даатгалын хүртээмжтэй, бүх нийтийн хөдөлмөр эрхлэлтийн нээлттэй бодлого явуулж, ард иргэдээ болзошгүй эрдлээс хамгаалана.

Боловсрол

ATA9693 9006109
9023030583

3.1 Үндэсний онцлогтой ерөнхий боловсролыг төрөөс онцгойлон анхаарч, сургалтын агуулга арга зүй, сурх бичгийн агуулгад улсын хэмжээгээр нэгдсэн судалгаа хийж, дүгнэлтийг УИХ-аар хэлэлциүүлж, нэгдсэн стандарт тогтооно.

3.2 Улсын нэгдсэн төвшин тогтоох шалгалтыг жил бүр, тусгайлан 10 ба 15 настнуудын дунд эх хэл, түүх, байгалийн шинжлэл, гадаад хэлний хичээлээр улс орон даяар нэгдсэн байдлаар явуулж сурлагын төвшин тогтоож байна.

3.3 Бага, дунд ангийн анги дүүргэлтийг 30-аас доошгүй хүүхэдтэй байхаар төлөвлөнө.

3.4 Аймаг, нийслэлийн дүүргүүд өөрийн хөрөнгө хүч, төсөв, санхүүгийн боломжоор Дүүргийн сургууль байгуулж болох хууль эрх зүйн боломжийг бүрдүүлнэ.

3.5 Хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулиудын төлбөрийг бодитой тогтооход анхаарч, боловсролоор бизнес хийх, хэт ашиг олохын эсрэг байна.

00000010

3.6 Ясль, цэцэрлэг, бага сургууль, төрөх эмнэлгүүдийг төлбөргүй болгохыг дэмжиж ажиллана.

3.7 Ясль, цэцэрлэгүүдийг хувьчлан авч, үйл ажиллагааг нь өөрчилж хувьдаа завшсан хувь хүмүүс, компаниас нийтийн сайн сайхны төлөө холбогдох хуулийн хүрээнд нөхөн төлбөр авах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.8 Их, дээд боловсролын тогтолцоог дэлхийн жишигт хүргэх, өрсөлдөх чадвартай болгох бодлогыг хэрэгжүүлнэ.

3.9 Их, дээд сургуулиудын багшлах боловсон хүчин хүний нөөц, сонгон шалгаруулалтыг ил тод болгож, дэлхийн топ 100 сургуульд магистр, докторын зэрэг хамгаалсан залуу эрдэмтэн, судлаачдыг өргөнөөр ажиллуулна.

3.10 Их, дээд сургуулиудыг дэлхийн болон Азийн шилдэг их сургуулиудын салбар сургуультай болгох, өргөтгөх бодлогыг хэрэгжүүлнэ.

3.11 Мэргэжлийн сургуулиудыг өргөтгөх, бааз суурийг бэхжүүлэх замаар зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үндэсний мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх материаллаг болон оюуны нөөцийг бурдуулнэ.

3.12 Мэргэжлийн сургалт, албан бус сургалт, зайн сургалт, түр сургалтын хэлбэрүүдийг зэрэгцүүлэн хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог нэвтрүүлнэ.

3.13 Шинжлэх ухааны үнэлэмжийг дээшлүүлж, шинэ нээлт, бүтээлийг урамшуулж, амьдралд нэвтрүүлэхэд төрөөс дэмжинэ.

3.14 Нийгмийн хариуцлагатай хувийн хэвшлийн байгууллагын боловсролын салбарт оруулсан хөрөнгө оруулалтыг хөхиулэн дэмжиж, төр, хувийн хэвшлын түншлэлийг хөгжүүлнэ.

3.15 Улс, олон улсын олимпиадын шагналт болон гоц авьяас билигтэй сурагчид, 1,2-р курсийн шилдэг оюутнуудаас сонгон шалгаруулж, дэлхийн шилдэг их, дээд сургуулиудад улсын тэтгэлгээр суралцуулах үндэсний хөтөлбөр боловсруулж, үе шаттай хэрэгжүүлнэ.

Эрүүл мэнд

3.16 Эрүүл монгол хүн бодлого, төслийг тасралтгүй хэрэгжүүлнэ.

3.17 Нийслэл болон улсын статустай хот, аймгийн төвүүдэд орчин үеийн эмчилгээ оношлогооны төв шат дараатай байгуулна.

00000011

3.18 Өмчийн хэлбэрийг үл харгалзан эмнэлгийн үйчилгээний чанар, стандартыг хангасан эмнэлгүүд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг болох эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

3.19 Өндөр өртөгтэй эмчилгээ, нөхөн сэргээлт, эмийн зардлын хөнгөлөлтийг төрөөс үзүүлж, хувийн болон улсын эрүүл мэндийн даатгалд хамруулахыг дэмжинэ.

3.20 Хувийн хэвшлээс эрүүл мэндийн салбарт оруулсан хөрөнгө оруулалтыг хөхиулэн дэмжих хууль санаачилна.

Нийгмийн халамж

3.21 Нийгмийн халамжийг хөдөлмөр эрхлэх чадваргүй эмзэг хэсэг, зорилтол бүлэгт чиглүүлж, төвлөрлийг сааруулах бодлогоор орон нутагт эрх мэдэл, Нийгмийн халамжийн сангийн менежментийг бүрэн шилжүүлнэ.

3.22 Төрөлт буурч, гэр бүл салалт ёсч, хүүхдийн хөгжил саатаж буй сөрөг үзэгдлийг бууруулах зорилгоор хүүхэд төрүүлсэн эх, нэн ядуу өрхийн болон гадаадад ажиллаж байгаа иргэдийн хүүхдүүдэд чиглэсэн улс төрийн шийдэлтэй тодорхой нийгмийн хамгааллын бодлогыг дэвшүүлнэ.

3.23 Хүүхэд төрөх, эрүүл саруул ёсч торних, амар тайван амьдралыг хангахад чиглэсэн нийгмийн хамгаалал, даатгалын зөв орчныг бүрдүүлнэ.

3.24 Залуу гэр бүлд зориулсан тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

3.25 Ахмад настны нийгэм хамгааллын зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагууд болон хувийн хэвшлийнхноэр гүйцэтгүүлж байх хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

3.26 Нийгмийн халамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн зардлын хоёрны нэгийг улсаас, дөрөвний нэгийг тухайн орон нутгийн төсвөөс, үлдсэн хэсгийг буюу үсгэн байгуулагчийн гаргах хэсгийг зээл хөрөнгө оруулалтын механизмаар шийдэх хуулийн орчныг бүрдүүлж ажиллана.

3.27 “Монгол хүний амьжиргаа хамгаалал, баталгааны тухай хууль” санаачилж, хүний амьжиргаа хамгааллын тусгай төсөв бий болгохын төлөө ажиллана.

3.28 Өрхийн сарын орлогын хэмжээ нь нэг хүнд ногдох хэмжээгээрээ амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур байгаа нөхцөлд зөрүүг төрөөс олгодог болох эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

3.29 Жилд тэрбумаас дээш орлоготой чинээлэг иргэдээс нийгмийн халамжийн төрийн бодлогыг дэмжих тусгай татвар авах хуулийн орчин бүрдүүлнэ.

3.30 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн дэд бүтцийг хөгжүүлэх, амьжиргааны баталгаа хангах, нийгмийн амьдралд эрх тэгш оролцох, ажиллах, хөгжих нөхцөл боломжийг байнга сайжруулна.

00000012

- 3.31 Малчин, тариаланч, фермерийн хүүхэд малын эмч, агрономч, фермерийн чиглэлээр суралцвал төрөөс их, дээд сургуульд хөнгөлттэй зээл, тэтгэлэгээр суралцуулна.

Нийгмийн даатгал

- 3.32 Нийгмийн даатгалын хэлбэр төрлийг нэмэгдүүлж, хувийн даатгалын тогтолцоог хөгжүүлнэ.
- 3.33 Нийгмийн даатгалын хөрөнгийг төсвийн санхүүжилтэд ашиглахыг хориглож, менежментийг бие даасан, хараат бусаар явуулах нөхцлийг бүрдүүлнэ.
- 3.34 Эрүүл мэндийн даатгалыг бие даасан тогтолцоонд шилжүүлнэ.
- 3.35 Давхар даатгалын тогтолцоог нэвтрүүлнэ.
- 3.36 Гадаадад ажиллаж, амьдардаг болон хүндэтгэх шалтгаантай иргэдэд нийгмийн даатгалаа нөхөн төлөх эрх зүйн боломжийг нээнэ.
- 3.37 **Өндөр төлбөртэй эмчилгээг эх орондоо хийлгэх бол зардлыг ЭМД-аас санхүүждэг болох эрх зүйн орчинг бүрдүүлнэ.**
- 3.38 Жирэмсний үеийн эхийн эруул мэндийн даатгалыг төр хариуцаж, эмчилгээ, сувилгаа, хэрэгцээт эм, амин дэмийг даатгалд хамруулна.
- 3.39 Хувь хүн өндөр шимтгэл төлөөд өндөр зэрэглэлийн тусгай тэтгэвэрт хамрагдаж болох хуулийн орчныг бүрдүүлнэ.
- 3.40 **Хөдөлмөр эрхлэлтийн даатгалын сангийн тухай хууль санаачилж, ажилтны хөдөлмөрлөх эрхийн TA9693 9006109 хамгаалж, ажил олгогчийн хариуцлагыг нэмэгдүүлнэ.**

Хөдөлмөр эрхлэлт

- 3.41 Хөдөлмөрийн насын буюу эдийн засгийн идэвхтэй хүн амын хөдөлмөрлөх эрхийг баталгаажуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогоор идэвхжүүлж, бүх нийтээр хөдөлмөрлөх нөхцөл, боломжоор хангана.
- 3.42 **Нэн ядуу хөдөлмөрийн насын иргэдийн ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг төр хариуцаж, ажилгүйдлийн даатгалын санг бүрэн бүрдүүлэх замаар ажилгүй иргэдийг ажилтай болох хугацааны тэтгэмж олгох хууль санаачилна.**
- 3.43 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

00000013

Зорилт 4.ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО:

Үндэсний аюулгүй байдлыг улстөр дипломатийн аргаар бэхжүүлж, тусгаар тогтнолоо баталгаажуулж, монгол хүн, монголын ард түмний нэр төртэй, аюулгүй, баталгаатай, эрүүл амьдрах орчныг бүрдүүлнэ.

Аюулгүй байдал

- 4.1 Төрийн бодлогод гадаад улс, хуулийн этгээд нөлөөлөх санаархал, оролдлогыг таслан зогсоон.
- 4.2 УИХ-аар хэлэлцэн дэмжигдээгүй , 2 удаа буцаагдсан хууль, тогтоолын төслийг тухайн парламентын бүрэн эрхийн хугацаанд дахин авч хэлэлцэхийг хориглоно.
- 4.3 Улсын нууцыг хамгаалах асуудлыг дээд түвшинд хургэж, задруулсан, эх ороносоо урvasан этгээдэд хуулийн дээд цээрлэл үзүүлнэ.
- 4.4 Терроризмтай хатуу тэмцэж, түүний аливаа илрэлийг шийдвэртэй таслан зогсоож, олон улстай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 4.5 Ялын дээд хэмжээ цаазаар авах ялын түдгэлзэлийг эрүүгийн нөхцөл байдал, олон нийтийн санаа бодлыг харгалzan дахин авч үзнэ.
- 4.6 Үндсэн хуулинд нийцээгүй олон улсын гэрээ, конвенцид нэгдэх, Монгол Улсад мөрдүүлэхийг хориглоно.
- 4.7 Үндэсний аюулгүй байдлын тогтолцоог шинэчлэн өргөжүүлж, бэхжүүлнэ.
- 4.8 Батлан хамгаалах бодлогыг улс төр, дипломатын аргаар бэхжүүлж,өөрийгөө хамгаалах цомхон, чадварлаг, мэргэжлийн арми, хил хамгаалах цэрэгтэй байхыг дэмжинэ.
- 4.9 Зөвхөн парламент зөвшөөрөн хууль баталснаар үндэсний армийг олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаа, дотоодын бүтээн байгуулалтад оролцуулахыг зөвшөөрнө.
- 4.10 Гадаад харилцааг улс төрийн болон эдийн засгийн дипломат бодлогыг хослуулан хөгжүүлнэ.
- 4.11 Хоёр хөрштэй тогтоосон найрсаг харилцаа, стратегийн түншлэлийг гүнзгийрүүлж, эдийн засгийн харилцааг либералчилна.
- 4.12 Дэлхийн улс орнуудтай эрх тэгш,нээлттэй,тэнцвэртэй харилцан хүндэтгэлтэй харилцааг тогтоож, дотоод хэрэгт үл оролцох зарчмыг мөрдөнө.

Байгаль орчин

- 4.13 Үндэсний эрчим хүчний бие даасан тогтолцоог бүрдүүлнэ.
- 4.14 Сэргээгдэх эрчим хүч, нар, салхины эрчим хүч ашиглах, хүлэмжийн хий багасгах чиглэлээр Монгол Улсын хэмжээнд баримталж байгаа хууль, олон улсын гэрээ, конвенцийн заалтыг хэрэгжүүлж ажиллана.

00000014

- 4.15 Нар, ус, салхи зэрэг байгалийн нөхөн сэргээгдэх эрчим хүчийг ашиглахыг төрөөс онцгойлон дэмжинэ.
- 4.16 Монгол Улсад технологийн бага оврын АЦС, устэрөгчийн станц байгуулах асуудлыг иргэдийн санал асуултыг үндэслэн хэлэлцэхийг шаардана.
- 4.17 Үйлдвэрлэлийн зориулалтаар гүний ус ашиглахад хяналт тогтооно.
- 4.18 Ой, усны нөөц ашигласны төлбөрийг нэмэгдүүлж, тэдгээрийг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулна.
- 4.19 Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хүн ам төвлөрсөн хот суурин газруудад шийдвэрлэж, төрөөс татвар, зээлийн бодлогоор урамшуулна.
- 4.20 Ой, рашаан булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, хуулийн этгээдийг төрөөс урамшуулна.
- 4.21 Нэн ховордсон ан амьтныг хамгаалах, ургамлыг нөхөн сэргээх тэдгээрийг дахин нутагшуулах эрх зүй, эдийн засгийн үндсийг бүрдүүлнэ.
- 4.22 Цөлжилт, хөрсний эвдрэл, түйрэн, элсний нүүдэлтэй тэмцэх зорилгоор ойг нөхөн сэргээх, говь, хээрийн бүсэд ногоон зурvas байгуулна.
- 4.23 Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд сэргээр нөлөөлөх арга технологиор ашигт малтмал олборлох, уул уурхайн үйлдвэрлэл явуулахыг хуулиар хориглоно.
- 4.24 Иргэдийн эрүүл аюулгүй орчин, хүнсний аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор гаалийн болон мэргэжлийн хяналтын лабораторын хүчин чадлыг нэмэгдүүлж, хүнс болон байгаль орчны хянан шинжилгээг сайжруулна.

Зорилт 5. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БОДЛОГО:

Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх бодлогыг тууштай дэмжинэ.

- 5.1 Авлигыг үндэсний хөгжлийн аюул занал гэж үзэж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд хуульчилан тэмцэнэ.
- 5.2 Авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тасрахгүй байхаар хуульчилж, бүх хөрөнгийг хураах, төрийн албанд ажиллах эрхийг бүрмөсөн хориглоно.
- 5.3 Авлигын гэмт хэргийг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдал, учруулсан хор уршиг, хохирлын хэмжээг харгалзан ялын ялгавартай бодлого баримтлана.
- 5.4 Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигыг үл тэвчих орчныг бүрдүүлж, олон нийтийн хяналт, иргэдийн шударга тэмцлийг дэмжинэ.
- 5.5 Авлигатай тэмцэх хууль, хяналтын байгууллагуудын эрх зүйн байдал, тогтолцооны шинэчлэлийг гүнзгийрүүлнэ.
- 5.6 Төрийн албаны авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх бодлогыг боловсронгүй болгож, зардал хянах тогтолцоог нэвтрүүлнэ.
- 5.7 Хувийн хэвшил, гадаадын байгууллага, компани, үндэстэн дамнасан корпорацийн авлигатай тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

00000015

5.8 Үзэл суртлын агуулгатай, авлигын шинжтэй төрийн шагналын системийг халж, алдаршуулах, урамшуулах бодлого гаргана.

5.9 НҮБ, гадаад орнуудын засгийн газрууд, олон улсын байгууллагуудтай эрх зүйн харилцан туслалцах гэрээ байгуулахыг эрчимжүүлж, хамтран ажиллаж гадаад дотоодод байгаа олигархиудын үл хөдлөх хөрөнгө, хувьцаа болон хадгаламжийг олон нийтэд ил тод болгоно.

Зорилт 6.ШИНЖЛЭХ УХААНЧ БОДЛОГО:

Байнга хувьсан өөрчлөгдөж, эрчимтэй хөгжиж буй дэлхий өртөнцөд үнэ цэнэтэй тоглогч, хүчтэй өрсөлдөгч байхын тулд цаг алдахгүй мэдлэгт тулгуурласан нээлттэй нийгмийг зорих болно.

6.1 Улс төр, эдийн засаг, нийгмийн бүх хүрээнд Монгол үндэстнийг мэдлэгт тулгуурласан нийгэмд шилжүүлэх үндэстний хөдөлгөөнийг бүх орон даяар төлөвлөгөөтэй хэрэгжүүлнэ.

6.2 Шинжлэх ухааны судалгааны тэргүүлэх чиглэлийг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, улс орны зорилттой уялдуулан тодорхойлж, хэрэгжих баталгаагаар хангана.

6.3 Төрийн бодлого төлөвлөлт, шийдвэр гаргах үйл ажиллагаа, хэрэгжүүлэлтийг шинжлэх ухаан, шинэ технологи, шилдэг менежментээр хөтөлнө.

6.4 Шинжлэх ухааны академи, их, дээд сургуулиудын судалгаа, шинжилгээний чадавхийг төвлөрүүлж, шинжлэх ухаан сургалт-үйлдвэрлэлийн нэгдлийг үүсгэн инновацийг амилуулах, нутагшуулах старт-ап компаниудыг байгуулж, бизнес инкубатор төвүүдэд бойжуулна.

6.5 Инновацийг нэвтрүүлэх, өндөр ~~ата~~ технологи нутагшуулах Үндэсний техник технологийн парк, цахим программ үйлдвэрлэх Үндэсний мэдээллийн технологийн парк, блокчейн технологи хөгжүүлж, Үндэсний биг дата төв байгуулна.

6.6 Улаанбаатарт олон улсын жишигт хүрсэн үндэсний нанотехнологи, биотехнологийн лабораторийн байгуулна.

6.7 Хиймэл оюун ухааныг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлнэ.

6.8 Сансарын тухай хууль санаачилна.

6.9 Өндөр технологийн судалгаа, шинжилгээг төрөөс санхүүжүүлнэ.

6.10 Шинжлэх ухааны нээлт, бүтээл, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, цахим технологи, хиймэл оюуныг хөгжүүлэх, судалгаа шинжилгээг гүнзгийрүүлэх, оюуны чадавхийг төвлөрүүлэх, шинэ залуу боловсон хүчнийг сургах, бэлтгэх, үндэсний чадварлаг компаний, шилдэг брэндийг төрүүлэх зорилгоор Оюунтны хотхон байгуулах эхлэлийг тавина.

00000016